



### АСАРГААНЫ ТЭТГЭМЖИЙГ ДАРААХ ИРГЭНД ОЛГОНО:

- 01** Бүтэн өнчин хүүхдийг үрчлэн авсан болон эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг асран хамгаалж, харгалзан дэмжиж байгаа;
- 02** Гэр бүлийн тухай хуулийн 25.5-д заасан болон хүчирхийллийн улмаас сэтгэл санааны болон бие махбодын хохирол хүлээж хамгаалалт шаардлагатай болсон хүүхдийг Гэр бүлийн тухай хуулийн 74 дүгээр зүйлд заасны дагуу гэр бүлдээ авч асрамжилж байгаа хүүхдийн аюулгүй байдлыг хангах зорилгоор Хүүхэд хамгааллын тухай хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд хамрагдаж байгаа;
- 03** Тэжээн тэтгэх хүүхэдгүй, ганц бие ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй ганц бие иргэнийг гэр бүлдээ авч асрамжилж байгаа;
- 04** Эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ба иргэнийг асарч байгаа.

### ИРГЭН АСАРГААНЫ ТЭТГЭМЖИЙГ АВАХ ХҮСЭЛТ ГАРГАХДАА ДАРААХ БАРИМТ БИЧГИЙГ БҮРДҮҮЛНЭ:

- 01** Бүтэн өнчин хүүхдийг үрчлэн авсан болон эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг асран хамгаалж, харгалзан дэмжиж байгаа иргэн.
1. Өргөдөл;
  2. 2 хувь зураг;
  3. Сум, хорооны Засаг даргын тодорхойлолт;
  4. Асруулагчийн иргэний үнэмлэх /16 насанд хүрээгүй бол төрсний гэрчилгээ/, хуулбарын хамт;
  5. Эцэг, эхийн нас барсны гэрчилгээ;
  6. Үрчлэн авсан, эсхүл асран хамгаалагч, харгалзан дэмжигчээр тогтоогдсон тухай сум, дүүргийн Засаг даргын захирамж, хуулбарын хамт;
  7. Асран хамгаалж, харгалзан дэмжиж байгаа хүний иргэний үнэмлэх, хуулбарын хамт;
  8. Сум, хорооны Амьжиргааг дэмжих зөвлөлийн шийдвэр.
- 02** Гэр бүлийн тухай хуулийн 25.5-д заасан болон хүчирхийллийн улмаас сэтгэл санааны болон бие махбодын хохирол хүлээж хамгаалалт шаардлагатай болсон хүүхдийг Гэр бүлийн тухай хуулийн 74 дүгээр зүйлд заасны дагуу гэр бүлдээ авч асрамжилж байгаа хүүхдийн аюулгүй байдлыг хангах зорилгоор Хүүхэд хамгааллын тухай хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд хамрагдаж байгаа иргэн.
1. Өргөдөл;
  2. Сум, хорооны Засаг даргын тодорхойлолт;
  3. 2 хувь зураг;

4. Иргэний үнэмлэх, хуулбарын хамт
  5. Асруулагчийн иргэний үнэмлэх /16 насанд хүрээгүй бол төрсний гэрчилгээ/, хуулбарын хамт;
  6. Эцэг, эх нь хоёулаа иргэний эрх зүйн чадамжгүй гэж тооцогдсон, эрх зүйн чадамжаа хязгаарлуулсан, эцэг, эх байх эрхээ хязгаарлуулсан, хасуулсан, түүнчлэн хорих газар ял эдэлж байгаа бол шүүхийн шийдвэр;
  7. Эцэг, эх нь удаан хугацаагаар (3 сараас дээш) эмнэлэгт эмчлүүлж байгаа бол эмнэлгийн ерөнхий эмчийн тодорхойлолт;
  8. Эцэг, эх нь хүүхдээ биечлэн тэжээн тэтгэх, асран халамжлах бололцоогүй, эсхүл тэжээн тэтгэхээс зайлсхийсэн хүний хүүхэд бол энэ тухай сум, хорооны Засаг даргын тодорхойлолт;
  9. Хүчирхийллийн улмаас хүүхдэд хамгаалалт шаардлагатай болсон бол энэ тухай цагдаагийн байгууллагын тодорхойлолт;
  10. Сум, хорооны Амьжиргааг дэмжих зөвлөлийн шийдвэр.
- 03** Тэжээн тэтгэх хүүхэдгүй, ганц бие ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй ганц бие иргэнийг гэр бүлдээ авч асрамжилж байгаа иргэн.
1. Өргөдөл;
  2. Сум, хорооны Засаг даргын тодорхойлолт;
  3. 2 хувь зураг;
  4. Асруулагчийн иргэний үнэмлэх /16 насанд хүрээгүй бол төрсний гэрчилгээ/, хуулбарын хамт;
  5. Асрагчийн иргэний үнэмлэх, хуулбарын хамт;
  6. Сум, хорооны Амьжиргааг дэмжих зөвлөлийн шийдвэр.

**04** Эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ба иргэнийг асарч байгаа иргэн.

1. Өргөдөл;
2. Сум, хорооны Засаг даргын тодорхойлолт;
3. 2 хувь зураг;
4. Иргэний үнэмлэх, хуулбарын хамт
5. Асруулагчийн иргэний үнэмлэх /16 насанд хүрээгүй бол төрсний гэрчилгээ/, хуулбарын хамт;
6. Байнгын асаргаа шаардлагатай ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ба иргэний тухайд Засгийн газрын 185 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 2.13-т заасан тодорхойлолт;
7. Сум, хорооны Амьжиргааг дэмжих зөвлөлийн шийдвэр.